

## ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙН ОЛИМПИАДЫН МЕДИА ДИЗАЙНЫ ТӨРЛИЙН II ШАТНЫ ДААЛГАВАР

**Даалгавар:** “МОНГОЛ СОЁЛ” СЭДЭВТ БОГИНО ХЭМЖЭЭНИЙ АНИМЕЙШНЫ  
ДҮР БҮТЭЭХ

***Зорилго:** Монгол үндэстний соёлын өв уламжлалаас судлан, шинэ зуунд хэрхэн  
хөгжиж ирээдүй хойчид өвлөгдөх нь зохистой талаар төсөөллөө илэрхийлэх.*

**Хэлбэр:** Дүрийн дизайны хуудас /Character Design Sheet/ зурах

**Баг:** Баг 3 хүртэл гишүүнтэй байна. Үнэлгээнд багийн гишүүдийн тоо биш ажлын  
гүйцэтгэлийн чанар гол үзүүлэлт болно!

**Гүйцэтгэх хугацаа:** /120 мин/

**ҮЕ ШАТ:**

### **А. УРЬДЧИЛАН БЭЛТГЭХ :**

- Текст боловсруулах программ бүхий зөөврийн компьютер
- Даалгавар гүйцэтгэх үйл явцын бичлэг хийх, CapCut зэрэг бичлэгийн хурдыг  
нэмэгдүүлэх аппликейшн суулгасан ухаалаг төхөөрөмж /гар утас, таблет г.м/
- Бичлэг хийх төхөөрөмжийг бэхлэх суурь
- Бичлэг хийх орчныг гэрэлтүүлэх нэмэлт гэрэл .
- Зургийн хэрэгсэл:
  - Балын харандаа
  - Баллуур
  - Бийр, усны сав
  - Будаг /өнгийн харандаа, усан будаг, гуашь г.м/
  - Өнгийн эсгий үзэг /Фломастер/
  - Гортиг, шугам
  - А2 цаас 1 ш, А3 цаас 2 ш

**Б. БОДИТ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР: 2025-04-06**

**Эхлэх цаг: 10:00. Дуусах цаг: 12:00 /120 минут/**

**Мэйл илгээх сүүлийн хугацаа:** 2026 оны 3-р сарын 6-ны 14 цаг 00 минут

**Даалгавар:** Сэдвийн дагуу анимейшны санаа боловсруулж гол дүрийг сонгон  
“Дүрийн дизайны хуудас /Character Design Sheet/ ” зурж гүйцэтгэнэ.

- А2 форматын цаасанд дүрийн үндсэн шийдэл болон хувцас өмсгөл, эдлэл  
хэрэглэлийг зохиомжлон зурна. Дүрийн нэр, түүх, тайлбарыг зохиомжлон  
бичнэ.
- Дүрийн нүүрний хувирал, сэтгэлийн хөдөлгөөнийг 8-с дээш хувилбараар А3  
форматын цаасанд зохиомжлон зурна
- Дүрийн бүтэн биеийн хөдөлгөөнийг 6-с дээш хувилбараар А3 форматын  
цаасанд зохиомжлон зурна
- Гүйцэтгэсэн ажлуудыг хуудас тус бүрээр болон зурагт үзүүлсэн байдлаар

нэгтгэн зургийг авна.

- Даалгавар гүйцэтгэх үйл явцын бичлэг хийж хурдасгасан байдлаар .mp4 форматаар видео файл болгож гаргана. Видео бичлэгийг хурдасгасан хэмжээг бичвэрт зааж өгнө.

### АНХААРАХ ЗҮЙЛС:


- Даалгаварыг зургийн дурын материалыг ашиглан гүйцэтгэж болно
- Зургийн нягтаршил /resolution/ 300dpi-с дээш чанартай байна.
- Видео бичлэгт багийн гишүүдийн ажиллагаа, бүтээлийн явцыг тодорхой харуулсан байна. Бичлэг хийх төхөөрөмжийн камерын өнцгийг үйл явцыг бүрэн харагдаж байхаар тохируулж байрлуулах буюу удирдагч багш эсвэл туслах хүн бичлэг хийж болно.
- **Бичлэгийн эхлэл, төгсгөлд эхэлсэн, дууссан цагийг харуулна.**
- Видео бичлэг даалгаварын үйл явцыг гүйцэтгэх хугацаанд эхэлснээс дуусах хүртэл /120 минут/ тасалдалгүй бичсэн байна. Төхөөрөмжийн цэнэгийг анхаарна уу!

Даалгавартай холбоотой тайлбар, бичвэрийг цахим хэлбэрээр (.docx, .pdf) хавсаргана.

Үүнд:

- Багийн нэр, сургууль, анги
- Багийн гишүүдийн нэр, цахим шуудангийн хаяг, утасны дугаар
- Анимейшны нэр
- Дүрүүдийн талаарх тайлбар
- Даалгавар гүйцэтгэхэд ашигласан ном, материал, эх сурвалжийн жагсаалт
- Видео файлыг хурдасгасан хэмжээ */Даалгаварыг гүйцэтгэсний дараа нэмж бичнэ/*

Бүтээлийн зургууд, бичвэр, видео бичлэгийг цахим шуудангийн [ch.munkhbayar@msue.edu.mn](mailto:ch.munkhbayar@msue.edu.mn) хаягаар илгээнэ.



Зураг